

**Д. НАЦАГДОРЖИЙН “ЛАМБУГАЙН НУЛИМС” ЗОХИОЛЫН
ЗӨРЧЛИЙН АСУУДАЛ**

И. Жавхлан*

Хүн төрөлхтний бүтээн туурвисан урлагийн гайхамшигт бүтээл үеэс үед дамжин уламжлагдаж, мөнх наслах хуггийг олж чадсан байдаг билээ. Он цагийн шалгуурыг давж эдүгээ хүртэл уншигч, судлаачдын сонирхлыг ихээхэн татсаар байгаа зохиол бол монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчийн нэг их зохиолч Д. Нацагдоржийн 1930 онд бичиж, хожим нь олны хүртээл болгосон “Ламбугайн нулимс” өгүүллэг юм. Уг зохиолын талаар гадаад дотоодын олон арван эрдэмтэд судалсан боловч өнөөг хүртэл маргаан мэтгэлцээнийг дагуулсаар байгаа нь их зохиолчийн авьяас билгийн илэрхийлэл, туурвин бүтээх гайхамшигийн илрэл гэлтэй. Нэг ёсондоо уншигч, судлаачдын таашаалыг хүлээн, өөр өөрсдийнхөөрөө үнэлж дүгнэх боломжийг олгож байдгаараа монголын орчин үеийн уран зохиолын шилдэг бүтээлийн нэг яах аргагүй болж чадсан билээ. Түүнчлэн Д. Нацагдоржийн “Харанхуй хад”, “Учиртай гурван толгой” зэрэг бүтээлүүд ч “Ламбугайн нулимс” зохиол лугаа нэгэн адил олон талын судалгаа шинжилгээ шаардсаар байгаа нь зохиолчийн суу билэг, урлахуйн гайхамшигтай нь холбоотой бизээ.

Судалгааны товч тойм:

1964 онд зохиолч Ч. Лодойдамба Д. Нацагдоржийн “Ламбугайн нулимс” зохиолын талаар “Нэгэн гайхамшигт үгүүллэгийн тухай” өгүүллийг бичиж сонинд хэвлүүлснээр уг зохиолын талаар судлагаа олон нийтийн анхаарлын төвд орсон гэж хэлж болох бөгөөд дээрх өгүүллийг гарсны дараагаар эрдэмтэн зохиолч Ш. Гаадамба “Нэгэн гайхалтай үгүүллийн тухай” хэмээх хариу шүүмж бичсэн байна. Учир нь “Ламбугайн нулимс” зохиолын Лодонгийн дүрийг Ч. Лодойдамба “...Энэ бол түүнийг ийм болгосон ёс суртахуун, сайн сайхан бүхнийг нь эвдэж хаясан нийгмийг ялласан их сэтгэлийн гашиуун нулимс мөн. Энэ бол түм түмэн сайхан эрчүүдийг хөдөлмөр, амьдралаас салгаж хаясан винайн ёсыг жигшиж хараасан нулимс мөн. Үүнд Лодонгийн дүрийн их чадал байгаа бөгөөд Лодон бол инээдэмт хүн биш харин эмгэнэлт хүн юм”¹ хэмээн үнэлсэнтэй холбоотой болно. Харин Ш. Гаадамба хариу болгож “Ч. Лодойдамбын дэвшүүлсэн шинэ санаа нь хэтэрхий зүрхтэй, гойд чөлөөтэйг гайхах хэрэггүй. Тэр шинэ

* Хүмүүнлигийн Их Сургууль, НХУС

¹) Лодойдамбай Ч (1964. III. 13), Нэгэн гайхамшигт үгүүллэгийн тухай. “Соёл утга зохиол” сонин. №11.

санаа нь юу гэвэл Лодон гэвчийн явдлыг амрагийн сайхан сэтгэл гэж баталсанд оршино. Лам нарын худал хуурмагийг илчилсэн шог үгүүллэгийг хүний сайхан сэтгэлийг нээж үзүүлсэн эмгэнэлт зохиол гэж тайлбарлажээ”² хэмээгээд “Туурвил нэг бүрийг тухайн нийгэм, түүхийн нөхцөл, орон цагтай нь салшгүй холбон судалж «Эдүгээчилэх» гаж буруу хандлагыг утга зохиолоос таягдан хаях нь зүйтэй”³-г анхааруулжээ. Улмаар Ч. Лодойдамбын “Баримт түшиж ярих сайхан!”⁴(1965), Б. Цэдэвийн “Юм үнэнээрээ сайхан”⁵(1965), С. Эрдэнийн “«Ламбугайн нулимс»-ны учир нэгэн бодол”⁶(1971), Д. Отгонсүрэнгийн “«Ламбугайн нулимс» өгүүллэгийн дүр, хэлний шүтэлцээ”⁷(1984), Ч. Жачингийн “«Ламбугайн нулимс»-ын үнэ цэн”⁸(1996), Казүюки Окадагийн “Д. Нацагдоржийн «Ламбугайн нулимс» өгүүллэгийн дүрийн асуудалд”⁹(1997) гэх мэт тусгайлсан судалгаа гарчээ. Мөн С. Лувсанвандангийн “Дашдоржийн Нацагдорж” (1966), К. Н. Яцковскаягийн “Дашдоржийн Нацагдорж” /жизнь и творчество/(1974), Л. Балдангийн “Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулгын зарим онцлог” (1978), Б. Содномын “Д. Нацагдоржийн зарим уран зохиолын судалгаа” (1980), Ц. Хасбаатарын “Д. Нацагдоржийн өгүүлэлт зохиолд хийсэн зарим нэг ажиглалт”¹⁰, “Д. Нацагдоржийн гар бичмэл” (1988), Д. Отгонсүрэнгийн “Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог” (1984), С. Лочингийн “Д. Нацагдоржийн зохиолын эх бичгийн судлалын асуудал” (1984), “Дашдоржийн Нацагдорж” (2000), “Бүрэн түүвэр” I, II, III(2006) зэрэг бүтээлүүдэд “Ламбугайн нулимс” зохиолын талаар судалгаа тодорхой хэмжээгээр хийгдсэн байна.

Дээр дурдсан бүтээлүүдэд “Ламбугайн нулимс” зохиолыг тал бүрээс нь судалсан бөгөөд эмгэнэлт хийгээд инээдэмт болох талаар анхлан гарсан маргаанд хариулт өгөхийг ямар нэгэн байдлаар хичээсэн тал ажиглагддаг. Д. Нацагдоржийн “Ламбугайн нулимс” бүтээлийн талаарх эрдэмтдийн судалгааг доорх байдлаар ангилан үзэх боломжтой юм. Үүнд:

1. Эмгэнэлтэй хийгээд инээдэмт зохиол эсэх буюу дүрийн судалгаа
2. Хэл найруулга, уран сайхны судалгаа

3. Эх бичгийн судалгаа зэрэг болно. Хэдийгээр ингэж ангилан үзэж байгаа боловч дээрх судалгаанууд бие биенээ нөхөн баяжуулсан нягт холбоотой байгааг хэлэх нь зүйтэй. Харин дээрх судалгаанаас хоёр болон гурав дахь ангилалын судалгаа төдийлөн маргаан дэгдээдэггүй бөгөөд эхний ангиллын судалгаа өнөө хэр бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Ч. Лодойдамба, Б. Содном, К. Н. Яцковская, Д. Намдаг, С. Лочин нарын судлаачид “Ламбугайн нулимс” өгүүллэгийг эмгэнэлт зохиол гэж үзсэн бол Ш. Гаадамба, Ц. Хасбаатар, Ч. Жачин нарын эрдэмтэд инээдэмт зохиол хэмээн үзсэн байна. Харин

² Гаадамба Ш (1964. XII. 18), Нэгэн гайхалтай үгүүллийн тухай, “Утга зохиол урлаг” сонин. №51

³ Мөн тэнд.

⁴ Лодойдамба Ч (1965. I. 22), Баримт түшиж ярих сайхан!. -“Утга зохиол урлаг” сонин. №4

⁵ Цэдэв Б (1995. VI. 24), Юм үнэнээрээ сайхан, “Улаанбаатар” сонин, №129-130.

⁶ Эрдэнэ С (1971. III. 12), “Ламбугайн нулимс”-ны учир нэгэн бодол, “Утга зохиол урлаг” сонин. №11

⁷ Отгонсүрэн Д (1984), Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог, Улаанбаатар, 141-148-р тал.

⁸ Жачин Ч (2013), Уран чадварын увидас, Улаанбаатар, 93-98-р тал.

⁹ Казүюки Окада (2014), Алтан харацай, Улаанбаатар, 33-42-р тал.

¹⁰ Дагвадорж Ч /редактор/ (1990), Д.Нацагдоржийн уламжлал, утга зохиолын өнөөгийн зангилаа асуудлууд, Улаанбаатар, 53-56.

японы монгол судлаач Казүюки Окада эдгээр судлаачдын саналыг нэгтгэн үзээд, уг зохиолыг:

“1. Энэ өгүүллэгийг хүний хувьд нь Лодонгийн «хайр дурлал»-ын явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл эмгэнэлтэй зохиол болно.

2. Энэ өгүүллэгийг лам санваартны хувьд нь Лодонгийн «завхай» явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл инээдэмтэй, шог хошин болно.

3. Энэ өгүүллэгийг зохиолч С. Эрдэнийн үзсэнээр Иүй Бай-хуа хэмээх Цэрэнлхамын «тачаангуй», «зальтай» явдлыг дүрсэлсэн зохиол гэж үзвэл, феодалын ялзарсан нийгмийг хурц шүүмжилсэн зохиол гэж болно”¹¹ хэмээсэн хувилбарт дүгнэлтийг хийжээ. Энэхүү дүгнэлт нь судлаачдын хоорондын маргааныг шийдвэрлэж чадаагүйн дээр, өөрийн гэсэн судалгааны хувь нэмэр оруулсан зүйл төдий л харагдахгүй байна.

Харин судлаачдын олон янз саналд хариу өгөхийн тулд өгүүлэгдэн буй зохиолын зөрчлийн асуудлыг гоо зүйн ухаантай холбон судалснаар тодорхой шийдэлд хүрэх боломжтой юм.

“Ламбугайн нулимс” өгүүллэгийн зөрчил

“Амьдрал бүхэлдээ зөрчил тэмцэл бөгөөд түүний уран сайхны илэрхийлэл болсон уран зохиолын ертөнц ч зөрчлөөр дүүрэн юм. Иймээс зохиолыг зөрчлөөс салангид тайлах аргагүй”¹² билээ. Ийм ч учраас дэлхийн уран зохиолын туршлагад нийгмийн анги бүлэг хоорондын, нийгэм болон хувь хүн хоорондын, байгаль хийгээд хүн хооронд, цусан төрлийн хооронд, хувь баатрын дотоод сэтгэлийн гэх мэт зөрчлийн тодорхой загварууд нэгэнт бий болсон байдаг. Түүнчлэн “Дэлхийн уран зохиолыг сэдвээр ангилан авч үзсэн судлаачид дэлхий бүх л уран зохиол 32-хон сэдэв дотор эргэлддэг гэдэг дүгнэлтийг нэлээд дээр үед хийсэн байдаг. XX зууны францын зохиолч Андре Моруа дэлхийн уран зохиолд давтагдаж байгаа 12 сэдвийг, италийн жүжгийн зохиолч К. Гоцци дэлхийн уран зохиолд буй эмгэнэлт зөрчлийн 36 загварыг, германы эрдэмтэн П. Меркер дэлхийн уран зохиолын үүдэн гарсан 100 шалтаг байгааг хожим нь гаргаж ирсэн байдаг”¹³ байна.

Юуны өмнө “Ламбугайн нулимс” зохиолын зөрчлийн асуудал бидний сонирхлыг татаж буй бөгөөд зөрчил гэгч чухамдаа аливаа зохиолын үйл явдлыг өрнүүлэн хөгжүүлж, амт шимтгэй, бодтой болгон, дүрүүдийн зан төрхийг нээж, утга санааг илэрхийлж байдаг чухал зүйл бөгөөд ерөөс зөрчилгүй зохиол гэж үгүй, харин түүний хэрхэн боловсруулах нь зохиолчийн уран санаа, ургуулан бодох чадвар, туурвин бүтээхүйн онцлог, уран сайхны нээлтийн илэрхийлэл болж байдаг билээ.

Уг зохиолын үйл явдал төдийлөн нарийн ээдрээтэй биш бөгөөд гол дүр Лодонгийн амьдралд гарсан өөрчлөлтийг Цэрэнлхамын дүрээр дамжуулан ихэд тодорхой үзүүлсэн байдаг. Зохиолын өгүүлэгдэхүүн “Орчлонт ертөнцийг хоосон хэмээх хүрдийг бясалгаж, винайн ёсыг сахисан гэвш Лодон улаан шарыг тунуулсаар, гандангийн наад хүр уруу бууж ирмэгц, уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан хүүхэн Иүй Бай-хуа гэдэг Цэрэнлхам цагаан харыг гялбалзуулсаар, баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэх нь эсрэг тохиолдов. Иүй Бай-хуагийн хар тамхи тасарсан учир, нэг алтан бөлзгийг бариулж, хэдэн янчаан олж хэрэглэхийг зорьж явсан нь санамсаргүй гэвш Лодон тохиолдохыг үзвэл, тэр үнэхээрийн нэг номхон хувраг

¹¹) Казүюки Окада (2014), Алтан хараацай, Улаанбаатар, 42-р тал.

¹²) Галбаатар Д (2012), Уран зохиол: онол, түүх, шүүмжлэлийн нэвтэрхий толь, Улаанбаатар, 188-р тал.

¹³) Батбаяр Д (2007), Бүтээхүйн зүй тогтол сайхныг бүтээх нууц, Улаанбаатар, 118-р тал.

бөгөөд сэтгэл зөөлөн, чанар хөнгөн болохыг хэдийнээ ажиглан таниад, хувилгаан адил нэг аргыг олж, ламын дэргэд зогсож, зовлонтой бөгөөд бахардсан царай гарган: «Ламбугай өршөө, манай хөгшин эх өвдөөд үхэхийг хүлээж байна. Хичээж манайд морилж, ном айлдаж хайрлана уу?» гэсэн хэсгээр зангилагдаж, улмаар энэхүү зангилаа хурц зөрчилгүйгээр аажим алгуураар өрнөн, зохиолын эцэст огцом эргэлтээр шийдвэрлэгдэж байна.

Өөрөөр хэлбэл, “«орчлон ертөнцийг хоосон гэж хүрд бясалгасан ламд» «ертөнцийн манан бяцхан пур пураар үүсч», улмаар «ертөнцийг сайшаах сэтгэл» төрж, «ертөнцийн хэргийг тааламжтайг» ойлгон, тэг тэгсээр «ертөнцийн цаламд» урхилагдаад, эцэст нь, «ертөнцийн хар нулимсыг борооны дусал адил асгаруулсан» явдлыг үзүүлжээ гэвэл болох бөгөөд үүнд эхний «орчлонт ертөнц» гэсэн нь «орчлон», «хорвоо», «дэлхий» гэсэн утгаар «ертөнцийн манан» гэсэн нь «хүсэл тачаал», «ертөнцийг сайшаах» гэсэн нь «хүүхнийг таалах», «ертөнцийг хэрэг» гэсэн нь «эр эмийн ёс», «ертөнцийн цалам» гэсэн нь «жирийн хүний аж амьдрал», «ертөнцийн хар нулимс» гэсэн нь «гэмшил гомдлын нулимс» гэсэн утгаар тус тус орсон нь сонирхолтой холбоо, ёгт нэр, ёгт дүрслэлийн шинжтэй болжээ. Эдгээр холбоо хэллэгүүд Лодон гэвшийн дүрийн хувьсал, хөгжил, сэтгэл санааны өөрчлөлтийг маш нарийн дэс дараатай товч гаргаснаар онцлог”¹⁴ юм. Нэг ёсондоо “Лодон гэвшийн Цэрэнлхам хүүхэнд татагдаж, түүнтэй цуг байвал яахаас ч буцахгүй болсныг хүртэлх сэтгэлийн хямрал зөрчил, хайр сэтгэлийг «Ертөнц» гэсэн үг бүхий таван хэллэгээр үзүүлсэн”¹⁵ байна.

“Ламбугайн нулимс” өгүүллэгийн төгсгөлд Лодон “байшингийн босгыг нь тэвэрч

Хүү минь би чамд хайртай

Одоо би хаана очих вэ?

Өөр хүнтэй ханилах хамаагүй

Гагцхүү намайг бүү орхи

гэж хоёр нүднээсээ ертөнцийн хар нулимсыг борооны дусал адил асгаруул”-ж буй нь зохиолын турш хэрхэх шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байсан зохиолын үйл явдал ийнхүү эрс эргэлтээр шийдвэрлэгдсэнээрээ өгүүллэгийг сэтгэл зүйн шинжтэй болгож байна. Уг зохиолд сэтгэл зүйн зөрчлийг эрс эргэлтээр эцсийн мөчид шийдвэрлэсэнээрээ эмгэнэлт өнгө аясыг илэрхийлж байна. Ийм сэтгэл зүйн зөрчлийг нарийн анхааралгүйгээр үнэлэлт дүгнэлт өгснөөс болж зарим судлаачид инээдэмт зохиол гэж үзэхэд хүрчээ. “Энэ бол түүнийг ийм болгосон ёс суртахуун, сайн сайхан бүхнийг нь эвдэж хаясан нийгмийг ялласан их сэтгэлийн гашуун нулимс”¹⁶, энэ бол “гэвшийн амьдралд гарч буй их өөрчлөлт, уй гашуу, эмгэнэлт зовлонг илэрхийлж”¹⁷ буй нулимс юм.

“Нацагдорж ямар нэгэн хэмжээгээр сэтгэл зүйн нарийн бүтэцтэй дүрийг бичих гэж оролдож байсан нь «Ламбугайн нулимс» өгүүллэгээр нь илэрсэн”¹⁸ бөгөөд “Лодон зөөлөн сэтгэлтэй, итгэмтгий. Тэр Цэрэнлхамын ов мэхийг гадарлаагүй, дурлал гэсэн

¹⁴) Отгонсүрэн Д (1984), Д.Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог, Улаанбаатар, 148-р тал.

¹⁵) Мөн тэнд, 146-р тал.

¹⁶) Лодойдамбай Ч (1964. III. 13), Нэгэн гайхамшигт үгүүллэгийн тухай, “Соёл утга зохиол” сонин. №11.

¹⁷) Лочин С (2006), Юндэн дурласан уу? Нансалмаа хардсан уу? болон бас бусын тухай, Улаанбаатар, 205-р тал.

¹⁸) Яцковская К. Н. (1976), Дашдоржийн Нацагдорж. Улаанбаатар, 104-р тал.

тоглоомыг нь таниагүй, хэдийгээр эхлээд их ариун сэтгэлээр бус очсон ч гэлээ, жинхэнэ хайр сэтгэлтэй болжээ.

Ер бусын тэгсэн атлаа мэхлэгдсэн энэ дурлалын хүүрнэн өгүүлэлд нь шууд л сургамжилсан юм байхгүй. Зохиолч Лодонгийн дүрийг бүтээхдээ бүрэлдэж тогтсон бэлэн зан төрхийг нэг нөхцөл байдлаас нөгөөд шилжүүдэг (бид ийм байдлыг Цэрэнлхамын жишээн дээр үзэж болно) уламжлалыг огоорч сэтгэл зүйн дүрийг бүтээн бий болгохыг зорьсон¹⁹ байна. Нэг ёсондоо энэхүү сэтгэл зүйн зөрчил нь ёс суртахууны үнэлэмжид хамаарах хууран мэхлэлтээр тайлагдаж байна.

Хэдийгээр “Ламбугайн нулимс” зохиол сэтгэл зүйн эмгэнэлт зөрчлийг нээж чадсан боловч бас дан ганц эмгэнэлт зохиол гэж үзэж боломооргүй байна. Учир нь уг зохиолыг судлан шинжилж эмгэнэлтэй зохиол болохыг өөрийн үзэл саналаар баталсан эрдэмтэд “Гэхдээ инээд хүрэх газар огт байхгүй гэж нэг талыг баримталан ярих юм бол үлэмж буруу болно. Эмгэнэлт зохиол хичнээн чадалтай болох тусмаа инээдэмт явдал их байдаг удаа бий”²⁰, тиймээс “«Ламбугайн нулимс» зохиолд шогийн өнгө аяс байхгүй гэсэн үг бус. Ер нь нэг зохиолоо ганцхан цагаан юм уу, улаан, эсвэл хар өнгийг эрнэ, тийм ганц өнгөөр л байх ёстой гэж шаардах нь тэнэглэл билээ. Нацагдоржийн уран чадварыг «Ламбугайн нулимс» зохиолоос ийнхүү мэдэж болно”²¹ гэж дүгнэсэн буй.

Энэ талаар эрдэмтэн Д. Цэдэв “Д. Нацагдорж зохиолоо загварт баригдалгүй олон талтайгаар инээдэм, гашуудал, уяруулал, догдлуулал, тэргүүнийг хослуулан туурвидгийн гэрч мөн. Үүнээс үзвэл, Д. Нацагдоржийн «Ламбагуайн нулимс» өгүүллэг, баатрын дүр нь шог инээдэм, эмгэнэлийн харилцан шүтэлцэж биесээ баяжуулсны бодит жишээг шинэ үеийн уран зохиолын хуудаснаа тодорхой харуулан өгчээ”²² хэмээгээд “Нэгэнт уул зохиол гүн гүнзгий утгатай, баатрын дүр нь олон талтай өвөрмөц болж чадсаны учир түүнийг загварчлан авч үзэж, зохиолын аль нэгэн төрөлд заавал шахан багтаах гэж оролдоход зохистой дүн гарахгүйд хүрнэ”²³ гэсэн байна.

Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” зохиолын эмгэнэлт хийгээд инээдэмт шинжийг гоо зүйн ухаантай холбон авч үзвэл илүү оновчтой болох юм. Гоо зүйн шинжлэх ухаанд эмгэнэлт категорийг өөдрөг эмгэнэлт явдал, гутрангуй эмгэнэлт явдал гэж ангилж үздэг бөгөөд бидний анхаарлыг гутрангуй эмгэнэлт явдал татаж байна. “Эмгэнэлт явдлын нэг өвөрмөц илрэл болох гутрангуй эмгэнэлт явдал нь хүн хүрээлэн буй орчин хийгээд бодит байдлын өмнө хүчин мөхөсдөж бүтээлч үйл ажиллагаагаа явуулж чадахгүй болсон холбоотой илэрч гардаг”²⁴ тул “Гутрангуй эмгэнэлт явдал нь хүн өөрийн хүчиндээ итгэх итгэлийг алдагдуулж, амьдралын сайхны төлөө тэмцэх эрмэлзэл, зорилгогүй болгож байдагт түүний гол уршиг оршино. Гутрангуй эмгэнэлт нь хүнийг оюун санааны хувьд доройтуулж, чин эрмэлзэлгүй болгоод зогсохгүй хамт олон, нийгмийн идэвхтэй гишүүн байх бололцоог хааж ганцаардмал байдалд оруулдаг. Хүн өөрөө өөрийгөө хүнийсгэж улмаар өөрөө өөрийгөө хүнийсгэх аюултай байдал нь гутрангуй эмгэнэлт явдалд хүргэнэ. Энэ утгаараа гутрангуй эмгэнэлт явдал нь инээдэмт зүйлийн категоритой холбогддог. Гутрангуй эмгэнэлт ба инээдэмт зүйл хоёрын

¹⁹) Мөн тэнд. 105-р тал.

²⁰) Лодойдамба Ч. (1965. I. 22), Баримт түшиж ярих сайхан!. “Утга зохиол урлаг” сонин. №4

²¹) Лочин С (2006), Юндэн дурласан уу? Нансалмаа хардсан уу? болон бас бусын тухай. Улаанбаатар, 205-р тал.

²²) Цэдэв Д (1978), Зохиолчийн урлах эрдэм. Улаанбаатар, 131-р тал.

²³) Мөн тэнд. 129-р тал.

²⁴) Төмөрбаатар Ж (2000), Гоо зүйн категориуд, Улаанбаатар, 51-р тал.

холбогдож буй харьцаанаас хамаараад «Эмгэнэлт-инээдэм», «Инээдэмт-эмгэнэл» гэсэн хэлбэрүүд гарч ирдэг. Эл байдал урлагийн бүтээлүүд дээр бүр ч тодорхой харагддаг”²⁵ байна.

Тухайлбал, “В. Шекспир, М. Горький, М. Шолохов зэрэг сонгодог зохиолчдын зохиолд инээдэм хийгээд эмгэнэл хослон нэгдсэн байх нь аль олонтаа. Ер нь шог зохиолд инээдэм эмгэнэлийн аяс ч байдаг. Эмгэнэлт зохиолд инээдэм шоглол ч бас байж болдог”²⁶-ийн жишээ цөөнгүй юм.

Түүнчлэн “Эмгэнэлт, инээдэмт зүйлийн шалтгаан бол хүний хязгааргүй хүсэл, хэмжээтэй бололцоо хоёрын зөрчлөөс эх үндэстэй нь үнэн болно. Энэ нь эмгэнэлт зөрчил, инээдэмт нөхцөлийн үндэс болно. Иймээс амьдралд энэ хоёр үзэгдлийг цэврээр харахад бэрх, харин урлагт тунгаан үзүүлнэ.

Х. Рембрандтын «Төөрсөн хүү эргэж ирсэн нь», К. Брюловын «Помпеин эцсийн шөнө», И. Репиний «Иван Грозный хүү, Иван хоёр» зурагт эмгэнэлт утга санааг хошин, шог өнгө аяс тодотгож хошин шог аясын гүнд эмгэнэлт зөрчил үйлчилж байдгийг гайхалтай үзүүлжээ”²⁷. Иймээс Д. Нацагдоржийн “Ламбугайн нулимс” зохиол сэтгэлзүйн эмгэнэлт зөрчлөөс үүдэлтэй, инээдэмт нөхцөл байдал бүхий “инээдэмт-эмгэнэл” төрлийн өгүүллэгийн сонгодог жишээ болно.

НОМ ЗҮЙ

1. Батбаяр Д. (2007), Бүтээхүйн зүй тогтол сайхныг бүтээх нууц, Улаанбаатар.
2. Гаадамба Ш. (1964. XII. 18) Нэгэн гайхалтай үгүүллийн тухай. -“Утга зохиол урлаг” сонин. №51
3. Галбаатар Д. (2012) Уран зохиол: онол, түүх, шүүмжлэлийн нэвтэрхий толь. Улаанбаатар.
4. Дагвадорж Ч. /редактор/ (1990), Д.Нацагдоржийн уламжлал, утга зохиолын өнгөөгийн зангилаа асуудлууд. Улаанбаатар.
5. Жачин Ч (2013), Уран чадварын увидас. Улаанбаатар.
6. Казююки Окада. (2014), Алтан хараацай. Улаанбаатар.
7. Лодойдамба Ч. (1965. I. 22), Баримт түшиж ярих сайхан!.-“Утга зохиол урлаг” сонин. №4.
8. Лодойдамбай Ч. (1964. III. 13), Нэгэн гайхамшигт үгүүллэгийн тухай.-“Соёл утга зохиол” сонин. №11.
9. Лочин С. (2006), Юндэн дурласан уу? Нансалмаа хардсан уу? болон бас бусын тухай. Улаанбаатар.
10. Лувсанвандан С. (1982), Марксист-ленинист гоо зүй. Улаанбаатар.
11. Отгонсүрэн Д. (1984), Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог”. Улаанбаатар.
12. Төмөрбаатар Ж. (2000), Гоо зүйн категориуд. Улаанбаатар.
13. Цэдэв Б. (1995. VI. 24), Юм үнэнээрээ сайхан, “Улаанбаатар” сонин. №129-130
14. Цэдэв Д. (1978), Зохиолчийн урлах эрдэм. Улаанбаатар.

²⁵) Мөн тэнд. 52-р тал

²⁶) Цэдэв Д (1978), Зохиолчийн урлах эрдэм. УБ., 30-р тал

²⁷) Лувсанвандан С (1982), Марксист-ленинист гоо зүй. УБ., 66-р тал

15. Эрдэнэ С. (1971. Ш. 12), “Ламбугайн нулимс”-ны учир нэгэн бодол. “Утга зохиол урлаг” сонин. №11.
16. Яцковская К. Н.(1976), Дашдоржийн Нацагдорж. Улаанбаатар.

SUMMARY

The story “Lambugai nulims” (meaning “Crying monk”) by Natsagdorj D. depicts psychologically tragic conflict of a monk. Therefore, the story belongs to the typology of “comical tragedy”.